

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянтэс сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ЗАА-2022/05/СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: www.audit.mn Улиастай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 70463612 Цахим хаяг: batundraa@audit.gov.mn Ахлах аудитор : Б.Дагвасүрэн Утас:99014227 Цахим хаяг:dagvasurenb@audit.gov.mn Аудитор П.Ганцолмон Утас:70157405 Цахим хаяг:ulistaivanaudit@ubaudit.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал, Шилэн дансны хуулийн хэрэгжилт, бусад хууль тогтоомж	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1. Төрийн аудитын санал, дүгнэлт


**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
81090 Улаанстай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

БЯАНТЭС СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Э.БАТЗОРИГ-Т

2022.05.24 № 1902/316
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянтэс сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас Баянтэс сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

- ✓ 12,114.6 мянган төгрөгийн зардлыг зориулалт бусаар зарцуулсан;
- ✓ 63,169.7 мянган төгрөгийн худалдан авалтын и баримтыг илүү бүрдүүлсэн;
- ✓ 7,632.9 мянган төгрөгийн бараа материалын тооллогыг хийгээгүй, тооцоог бодоогүй;
- ✓ 11,304.2 мянган төгрөгийг хувь хүний дансаар дамжуулан зарцуулахдаа бэлэн мөнгөний гүйлгээний тайлан гаргаагүй;
- ✓ 1,656.5 мянган төгрөгийн цалингийн урамшууллыг олгохдоо удирдлагын шийдвэрийг мөрдөөгүй;
- ✓ 5,763.9 мянган төгрөгийн шатахууны тооцоо бодоогүй;

Эдгээр зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7; 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6; Татварын ерөнхий хуулийн 28.2; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3 дахь заалтууд, Төрийн сангийн төлбөр тооцооны журам, жижиг мөнгөн сангийн журам зэргийг зөрчсөн, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА



Хүлээн авсан
2022.05.24
Хүлээн авсан
2022.05.24

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	7,632,936.00	7,632,936.00
35	БАРАА МАТЕРИАЛ	7,632,936.00	7,632,936.00
354	Хангамжийн материал	7,632,936.00	7,632,936.00
35410	Бичиг хэргийн материал	566,840.00	566,840.00
35420	Аж ахуйн материал	7,066,096.00	7,066,096.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	608,716,830.08	638,456,465.87
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	608,716,830.08	638,456,465.87
392	Биет хөрөнгө	575,868,830.08	605,938,465.87
39201	Барилга, байгууламж, орон сууц	544,955,324.85	604,705,324.85
39202	Хуримтлагдсан элэгдэл	(82,504,017.37)	(112,492,085.53)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	103,021,800.00	103,021,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(65,290,102.13)	(75,710,787.77)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	67,097,695.40	79,664,295.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(59,013,538.81)	(61,183,317.62)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	95,525,012.00	107,751,106.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(66,900,371.14)	(72,832,608.87)
39214	Бусад үндсэн хөрөнгө	117,206,788.00	117,206,788.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(78,657,660.72)	(84,619,948.59)
39217	Ном	427,900.00	427,900.00
393	Биет бус хөрөнгө	32,848,000.00	32,518,000.00
39301	Програм хангамж	3,022,000.00	3,022,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,372,000.00)	(1,702,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	31,198,000.00	31,198,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I-II	616,349,766.08	646,089,401.87
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	616,349,766.08	646,089,401.87
51	Засгийн газрын хувь оролцоо	616,349,766.08	646,089,401.87
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
		394,749,005.52	394,749,005.52
51101	Өмч: - төрийн	394,749,005.52	394,749,005.52
512	Хуримтлагдсан үр дүн	194,654,453.75	224,394,089.54
51210	Өмнөх үеийн үр дүн	197,085,547.84	194,654,453.75
51220	Тайлант үеийн үр дүн	(2,431,094.09)	29,739,635.79
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	26,946,306.81	26,946,306.81
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	616,349,766.08	646,089,401.87

2.2 Аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	439,147,433.00	476,508,991.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	56,786,140.00	25,450,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	56,786,140.00	25,450,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	56,786,140.00	25,450,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	56,786,140.00	25,450,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	382,361,293.00	451,058,991.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,678,543.00	51,972,791.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,678,543.00	51,972,791.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	368,682,750.00	399,086,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	363,900,550.00	399,086,200.00
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	4,782,200.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	441,578,527.09	446,769,355.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	441,578,527.09	446,769,355.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	385,984,341.90	416,782,655.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	226,361,102.89	226,621,173.00
210101	Үндсэн цалин	226,361,102.89	214,968,944.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	11,652,229.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,403,369.00	28,728,027.00
210201	Тэтгэврийн даатгал	19,514,329.00	20,219,335.35
210202	Тэтгэмжийн даатгал	2,261,463.00	2,249,004.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,809,169.00	1,799,203.33
210204	Ажил үйлдлийн даатгал	438,038.00	405,499.17
210205	Эрүүл мэндийн даатгал	4,380,370.00	4,054,984.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,360,339.92	27,231,000.00
210301	Гэрэл, цахилгаан	2,771,199.92	2,660,400.00
210302	Түлш, халаалт	18,589,140.00	24,570,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,828,882.00	27,015,020.00
210401	Бичиг хэрэг	3,310,300.00	3,310,300.00
210402	Тээвэр, шатахуун	17,600,982.00	19,580,320.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,917,600.00	3,918,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	206,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,261,000.00	15,610,186.00
210604	Урсгал засвар	4,261,000.00	15,610,186.00
2107	Томилголт, зочны зардал	4,572,100.00	4,572,100.00
210702	Дотоод албан томилолт	4,572,100.00	4,572,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,431,968.00	3,588,461.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	4,210,488.00	2,330,461.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	232,100.00	232,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	313,880.00	469,100.00

Баянтэс сумын Засаг дарын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210804	Тээврийн хэрэгслийн татвар	141,200.00	141,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73,800.00	73,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	322,100.00	203,400.00
210807	Газрын төлбөр	138,400.00	138,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	70,765,580.09	83,416,688.21
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,976,750.00	28,310,230.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303,400.00	303,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	53,485,430.09	54,803,058.21
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,594,185.19	29,986,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,792,900.00	29,884,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн	36,792,900.00	29,884,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,801,285.19	102,200.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,801,285.19	102,200.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(2,431,094.09)	29,739,635.79
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(2,431,094.09)	29,739,635.79

2.3 Аудит хийсэн Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	394,749,005.52	26,946,306.81	197,085,547.84	618,780,860.17
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	394,749,005.52	26,946,306.81	197,085,547.84	618,780,860.17
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(2,431,094.09)	(2,431,094.09)
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	394,749,005.52	26,946,306.81	194,654,453.75	616,349,766.08
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	394,749,005.52	26,946,306.81	194,654,453.75	616,349,766.08
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	394,749,005.52	26,946,306.81	194,654,453.75	616,349,766.08
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт,	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадвал валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	29,739,635.79	29,739,635.79
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	394,749,005.52	26,946,306.81	224,394,089.54	646,089,401.87

2.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Давсны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	382,361,293.00	451,058,991.00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	382,361,293.00	451,058,991.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,678,543.00	51,972,791.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,678,543.00	51,972,791.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	368,682,750.00	399,086,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	363,900,550.00	399,086,200.00
132005	Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/	4,782,200.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВ ЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	380,711,293.00	391,966,297.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	380,711,293.00	391,966,297.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	325,117,107.81	361,979,597.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	225,078,102.89	224,977,400.00
210101	Үндсэн цалин	202,009,107.89	199,697,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	23,068,995.00	25,280,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,686,369.00	30,371,800.00
210201	Тэтгэрийн даатгал	20,797,329.00	21,264,800.00
210202	Гэтгэмжийн даатгал	2,261,463.00	2,249,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,809,169.00	1,907,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	438,038.00	450,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,380,370.00	4,499,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,071,199.92	27,231,000.00
210301	Гэрэл, цахилгаан	2,771,199.92	2,660,400.00
210302	Тулш, халаалт	11,300,000.00	24,570,600.00
2104	Хянгамж, бараа материалын зардал	24,736,218.00	27,015,020.00
210401	Бичиг хэрэг	3,310,300.00	3,310,300.00
210402	Тээвэр, шатахуун	17,508,318.00	19,580,320.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,917,600.00	3,918,400.00
210406	Бага үнэтэй, тургэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	206,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,261,000.00	15,610,186.00
210604	Урсгал засвар	4,261,000.00	15,610,186.00
2107	Томилголт, зочны зардал	4,572,100.00	4,572,100.00
210702	Дотоод албан томилолт	4,572,100.00	4,572,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлдсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,431,968.00	3,588,461.00
210801	Бусдаар гүйцэтгүүлдсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,210,488.00	2,330,461.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	232,100.00	232,100.00
210803	Даатгалын үйлчилгээ	313,880.00	469,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	141,200.00	141,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73,800.00	73,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	322,100.00	203,400.00
210807	Газрын төлбөр	138,400.00	138,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,280,150.00	28,613,630.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,976,750.00	28,310,230.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303,400.00	303,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,594,185.19	29,986,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,792,900.00	29,884,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	36,792,900.00	29,884,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	18,801,285.19	102,200.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,801,285.19	102,200.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВ ЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,650,000.00	59,092,694.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,650,000.00	59,092,694.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,650,000.00	59,092,694.00
2200	Дотоод эхүүсвэрээр	1,650,000.00	59,092,694.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,650,000.00	59,092,694.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВ ЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1,650,000.00)	(59,092,694.00)
8	НИЙТ ЦЭВ ЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	364,086,000.00	399,086,200.00	35,000,200.00	110%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	364,086,000.00	399,086,200.00	35,000,200.00	110%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	334,201,500.00	369,099,500.00	34,898,000.00	110%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	224,977,400.00	224,977,400.00	-	100%
210101	Үндсэн цалин	199,697,000.00	199,697,000.00	-	100%
210105	Гэрээт ажлын хөлс	25,280,400.00	25,280,400.00	-	100%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,371,800.00	30,371,800.00	-	100%
210201	Тэтгэврийн даатгал	21,372,800.00	21,264,800.00	(108,000.00)	99%
210202	Тэтгэмжийн даатгал	2,249,800.00	2,249,800.00	-	100%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,799,700.00	1,907,700.00	108,000.00	106%
210204	Ажилүйлийн даатгал	450,000.00	450,000.00	-	100%
210205	Эрүүл мэндийн даатгал	4,499,500.00	4,499,500.00	-	100%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,231,000.00	27,231,000.00	-	100%
210301	Гэрэл, цахилгаан	2,771,200.00	2,660,400.00	(110,800.00)	96%
210302	Түлц, халаалт	24,459,800.00	24,570,600.00	110,800.00	100%
2104	Хангамж, бараа материалын зардал	19,736,200.00	43,768,500.00	24,032,300.00	222%
210401	Бичиг хэрэг	3,310,300.00	3,310,300.00	-	100%
210402	Тээвэр, шатахуун	12,508,300.00	19,580,320.00	7,072,020.00	157%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,917,600.00	3,918,700.00	1,100.00	100%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	16,959,180.00	16,959,180.00	
2106	Эд хөгшил, урсгал засварын зардал	22,949,400.00	17,949,400.00	(5,000,000.00)	78%
210604	Урсгал засвар	22,949,400.00	17,949,400.00	(5,000,000.00)	78%
2107	Томилголт, зочны зардал	4,572,100.00	4,572,100.00	-	100%
210702	Дотоод албан томилолт	4,572,100.00	4,572,100.00	-	100%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,360,200.00	2,637,400.00	1,277,200.00	194%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,379,400.00	1,379,400.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	232,100.00	232,100.00	-	100%
210803	Даатгалын үйлчилгээ	469,100.00	469,100.00	-	100%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,700.00	141,200.00	(86,500.00)	62%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	73,800.00	73,800.00	-	100%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203,400.00	203,400.00	-	100%
210807	Газрын төлбөр	138,400.00	138,400.00	-	100%
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15,700.00	-	(15,700.00)	0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,003,400.00	17,591,900.00	14,588,500.00	586%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,700,000.00	17,288,500.00	14,588,500.00	640%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303,400.00	303,400.00	-	100%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,884,500.00	29,986,700.00	102,200.00	100%
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	102,200.00	102,200.00	
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	102,200.00	102,200.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,884,500.00	29,884,500.00	-	100%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,884,500.00	29,884,500.00	-	100%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	364,086,000.00	399,086,200.00	35,000,200.00	110%
1320	ОРОН НУГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	364,086,000.00	399,086,200.00	35,000,200.00	110%
122005	Орон нутгийн төсвөөс	364,086,000.00	399,086,200.00	35,000,200.00	110%

2.6 Аудит хийсэн Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	51,972,791.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,972,791.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,972,791.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	951,061.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	951,061.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,021,730.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,021,730.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	40,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	40,000,000.00
223001	Бусад хөрөнгө	40,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	51,972,791.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	51,972,791.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	51,972,791.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянтэс сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Баянтэс сумын ЗДТГ-тай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Улиастай ван аудит ХХК-ийн ахлах аудитор П.Ганцолмон, аудитор Д.Гэрэлхүү нар гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянтэс сумын ЗДТГ-т 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дугаар сарын 21-ны өдрийн 03/22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянтэс сумын ЗДТГазар нь Засаг даргын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын туслалцаа үзүүлж, ажиллах нөхцөл бололцоогоор хангахын зэрэгцээ цаг үеэ олсон, мэргэжлийн зөвлөлгөө, дэмжлэгээр шуурхай хангах замаар хууль тогтоомж, бусад эрх зүйн хэм хэмжээний акт, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг аймгийн нутаг дэвсгэрт бүрэн дүүрэн хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг бүхий ажлын алба юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянтэс сумын ЗДТГазар нь Дотоод аудитын нэгж байхгүй.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл

үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино. Өмнө Баянтэс сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг дахин тогтоож АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл 2,500.0 мянган төгрөг гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 70 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлогын 476,500 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,700.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон материаллаг байдлын 70 хувиар буюу 2,500.0 мянган төгрөгөөр тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага			-
Бараа	7,632.9	7,632.9	-
Үндсэн хөрөнгө	608,716.8	638,456.5	29,739.7
Нийт хөрөнгө	616,349.7	646,089.4	29,739.7
Өр төлбөр			-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	616,349.7	646,089.4	29,739.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө	616,349.7	646,089.4	29,739.7

Бараа материалын дансны 7,632.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь эхэлж авснаа эхэлж зарлагадах аргыг хэрэглээгүй бүртгэлээр тавих хяналт сул байна.

Тайлант оны эцэст 29,739.6 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдсэн нь хандив тусламжаар 5,700.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, багийн барилга шинээр ашиглалтанд орж 19,750.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Төсвийн хөрөнгөөр багийн барилга 40,000.0 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 6,866.6 мянга, тавилга эд хогшил 12,226.1 мянган төгрөгөөр тус тус худалдан авч нийт үндсэн хөрөнгийн данс 84,5 сая төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 29,739.7 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгийн орлого өссөнтэй холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 29,739.7 мянган төгрөг болж өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 399,086.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж батлуулсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 399,086.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 398,984.0 төгрөгийг зарцуулж, 102.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны төсөв захирагчаас хуваарилсан төсөв 51,972.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлэн бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжинд 11,972.79 мянга, хөрөнгийн зардалд 40,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Нягтлан бодогч нь худалдан авалт хийхдээ и баримтыг бүрэн бүрдүүлээгүй, эд хариуцагч болон жолоочтой тооцоо бодож хэвшээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 148 мэдээллээс 138 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон мэдээлэл 4 мэдээлээгүй 6 мэдээлэл, хугацаа болоогүй 5 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмж хүргүүлснийг биелүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн Дугаар 276 дугаар тушаалын хавсралт “ Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллах,

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 45,010.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 12,120.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 15,968.1 мянган төгрөгийн алдаанд албан шаардлага, 15,265.8 мянган төгрөгийн алдаанд зөвлөмж, 1,656.5 мянган төгрөгийн алдаанд акт хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Шаардлагатай Үндсэн хөрөнгийг төсөвт багтаан худалдан авч, орлогот тусгах Өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүдийн санал, төсөв захирагчийн ТУШААЛ зэргийг худалдан авсан 12,120.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөнд гаргуулсан болно. Өглөг авлагуудыг тооцооны үлдэгдэл маягаар баталгаажуулсан.

4.2 Төлбөрийн акт:

- ✓ *Илрүүлэлт:* Ажилтан албан хаагчдад олгох урамшуулалын тушаалаар олгох нэмэгдлийг Цалингийн зөрүү гэж төөрөгдүүлэх маягаар 18 хүнд 40 хувиар тооцон олгосон бөгөөд тушаалд 16 хүнд 25 хувиар урамшуулал тооцон олгох хавсралт оруулсан 1,656.5 мянган төгрөгийн зөрчилд акт хүргүүлсэн болно.
- ✓ *Зөвлөмж:* Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн Дугаар 276 дугаар тушаалын хавсралт “ Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллах, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16 дугаар зүйлийн 16.5.4-д “Төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “Жинхэнэ хэрэгжилтийн” гэсэн заалтуудыг мөрдөн ажиллах

4.3 Албан шаардлага: Нярав Дулмаагийн хувийн 5496088789 тоот Хаан банкны дансруу 10,204.2 мянган төгрөгийг шилжүүлснийг бэлнээр авч зарцуулсан боловч бэлэн мөнгөний зарцуулалтын тайлан хийгээгүй , анхан шатны баримтын бүрдэл дутуу, хувь хүнд олгосон бэлэн мөнгөний и баримт болон татвар суутгалгүй шууд зарцуулсан 10,204.2 мянган төгрөгт мөн Жолоочын замын хуудасыг дугаарлаж нэгтгэж тээвэр шатахууны тооцоо бодсон тайлан байхгүй 5,763.9 мянган төгрөгт тус тус албан шаардлага хүргүүлж байгаа болно.

- ✓ *Илрүүлэлт:* 21,029.7 мянган төгрөгийн шатахууны тооцооны хуудсыг жолооч бичээгүй, эрх бүхий ажилтнууд хянаж баталгаажуулаагүй; Бараа материалын тооллого хийж тооцоо бодоогүй.
- ✓ *Зөвлөмж:* Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах;
- ✓ Эд хариуцагч болон жолоочийн тооцоог хянах ажлыг сайжруулах, зардлыг бүртгэхдээ бараа материалын дансаар дамжуулах, эд хариуцагчаар хөрөнгийг бэлтгүүлэн, бараа материалын тайланг хугацаанд нь гаргуулан, тооцоо бодож хэвших

4.4 Зөвлөмж

Аудитаар илэрсэн 15,265.8 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Тооцоо бодсон актгүй:**

- ✓ *Илрүүлэлт:* Тооллогын бүртгэл тушаалгүй, гарын үсэггүй, тооцоо бодсон актгүй, Үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэл дутуу, 7,632.9 мянган төгрөгийн бараа материалын тооллого байхгүй байна.
- ✓ *Өгсөн зөвлөмж:* Эд хариуцагч болон жолоочийн тооцоог хянах ажлыг сайжруулах, зардлыг бүртгэхдээ бараа материалын дансаар дамжуулах, эд хариуцагчаар хөрөнгийг бэлтгүүлэн, бараа материалын тайланг хугацаанд нь гаргуулан, тооцоо бодож хэвших

2. **Бараа материалын дансны үлдэгдэл хөдөлгөөнд ороогүй.**

- ✓ *Илрүүлэлт:* 2020 оны 7,632.9 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэл 2021 онд хөдөлгөөнд ороогүй байгаа нь бүртгэлээр тавих хяналт энэ байгууллагад байхгүй байна.
- ✓ *Өгсөн зөвлөмж:* Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16 дугаар зүйлийн 16.5.4-д “Төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “Жинхэнэ хэрэгжилтийн” гэсэн заалтуудыг мөрдөн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгуул	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянтэс ЗДТГ	6	45.0	1	12.1	1	1.7	2	16.0	2	15.3